大学蒙古语专业教材

# 蒙 古 语 阅 读

## 三年级第二册

编注　李剑　齐心

中国人民解放军外国语学院

一九九二年六月

# ГАРЧИГ


9 дүгээр хичээл МИНИЙ ГЭДЭГ УЛС ГЭР МИНЬ.......1

10 дугаар хичээл УЯНГЫН ЯРУУ НАЙРАГ ДАХЬ УРАН САЙХНЫ СЭТГЭМЖ..........22

11 дүгээр хичээл БНМАУ-ын ТҮҮХнээс...............41

12 дугаар хичээл МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ ТУХАЙ ..................................56

13 дугаар хичээл МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО...........71

14 дүгээр хичээл МОНГОЛЧУУДЫН АЖ БАЙДАЛ, ЗАН ЗАНШИЛ (1) .....................84

15 дугаар хичээл МОНГОЛЧУУДЫН АЖ БАЙДАЛ ЗАН ЗАНШИЛ (2).....................99

16 дугаар хичээл МОНГОЛЫН ШАШИН ШҮТЛЭГ.......112

9 дүгээр хичээл

## МАНАЙХ ГЭДЭГ УЛС ГЭР МИНЬ

(Найрагдал)

1

Цэнгэг нууранд хөвсөн
Аварга цагаан хун шиг
Цэнхэр тэнгэрт мэлтийсэн
Арван тавны сар шиг
Азийн цээжинд гэрэлтсэн
Өгөөмөр цагаан гэр бий
Ам бүл нь жаргасан
Өөдрөг сайхан айл бий.
Хорь дахь зууны үүрээр
Энэ айлын түүхэнд
Хордоо дайнд дуурссан
Үйл явдал болсон юм.
Хонгор морь адуунд
Далхин доор өсөж
Хотол баатар гэрт
Дайсан доор бойжиж
Бурангуй ёсыг халж
Шударга ёсыг тогтоохоор

Бүлт олноо жаргуулсан
Шинэ байдал үүсгэхээр
Энгийн гэрийн эрхийг
Үүрийн туяанаар татаж
Эрэлхэг жанжин Сүхбаатар
Үүдийг нь гэр дээр тавьж
Зуун жилийн нойрноос
Түмэн олноо сэрээж
Зузаан эвийн хүчээр
Түрэмгий хоноцыг нь хөөж,
Хуучин бор гэрийн
Ноорхой туургыг хаяж
Хорол эрдэнийн тооноо
Нийт олноороо тулж
Жаргалын улаан нарыг
Эрхэн дээрээ мандуулж
Жалхаат цагаан гэрээ
Өвгөдийн буурь дээр барьсан юм.
Тэр өдрөөс эхлэн
Өвгөдийн хүсэл биелж
Тэнгэр тиврын савсалганд

Өрх гэр шинэчлэгдэж
Өргөө цагаан гэрээсээ
Цэнхэр утаагаа суунаглуулж
Өнөр өтгөн ам бүлээрээ
Нэгэн гэртээ цуглаж
Түлсэн галын нь дөл
Үеийн үед бадарсан юм
Түмэн олны нь заяа
Улаан туг шиг гэрэлтсэн юм.
Ази тивийн цээжин дэх
Арван тавны сар,
Ам бүлийнхээ зүрхэн дэх
Амин хайртай гэр
Эрдэнийн цагаан өргөөтэй
Энэ сайхан айлын
Алдар нь гэвэл Монгол !
Ам бүлдээ бол Манайх !

Ази тивийн цээжин дэх
Арван тавны сар,
Ам бүлийнхээ зүрхэн дэх



此为试读,需要完整PDF请访问: www.ertongbook.com

Амин хайртай гэр
Алдар нэр нь Монгол гэдэг
Ам бүл нь манайх гэдэг
Манхан цагаан өргөө минь
Өнөр олон ам бүлтэй
Магнаг хөх тэнгэрийн доор
Өнөр өтгөн ах дүүстэй
Өөрийн шилбэнээс өөр
Амьтны хөл хүндээгүй
Зэрлэг онгон талаа
Алтан тариагаар хучиж
Ардаг морьныхоо жолоог
Аварга комбайнаар солиод
Атрын сайхан хөндийд
Аялан дуулж яваа
Үгийн сэргэлэн залуус
Удам залгах ажилчид бол
Манай гэрийн хүмүүс
Манай ам бүлийнхэн.
Дөрөлж дамнан баглаирсан
Таван эрдэнийн сүргээ

Дөрвөн улирал ээлжилсэн
Тэнгэр нутагтаа хариулж
Энгийн алганы хээтэй
Уургаа тулж мордоод
Эрэмгий хүлгийн нуруун дээр
Уртын дуугаа аялсан
Уул талын нэгдэлчин
Удам залгасан малчид бол
Манай гэрийн хүмүүс
Манай ам бүлийнхэн.
Эрвээхий нүдтэй жаалыг
Эрдмийн заяд нь түшиж
Эрийн цэнд хүрэхээр нь
Өөрийн суудлыг тавьж
Залгамж хойч үеэ
Энгийн сургаалаар хүмүүжүүлж
Заяа золтой олноо
Эрдэм номоор гэгээрүүлсэн
Ачит мэргэн багш
Ардын олон сэхээтэн бол
Манай гэрийн хүмүүс

Манай ам бүлийнхэн.

Ажилчин, малчин сэхээтний
Манхан цагаан өргөө минь
Ариун сайхан хоймортоо
Хүндэтгэлийн их олбогтой
Халуун бүлийнхээ дотроос
Алдар гавьяаны эздээ
Хоймрын өндөр олбогтоо
Урьж суулгадаг заншилтай.
Ган тулгаа тойрон
Хамт олноороо суугаад
Гадаа гэр дэх ажлаа
Хамтарч хийдэг журамтай
Хаяа хатавчны гадаа
Хэн нэг нь хоцордоггүй
Халуун ам бүлээрээ
Тэгш эрхийн суудалтай
Хүйс насны ялгаваргүй
Тэгшхэн эрхээ эдэлж

Хөгшин залуугүй бүгдээрээ
Ажил хөдөлмөрт шамдаг
Хүүхэд нялхам олонтой
Гэр бүлийнхээ ачааг
Хүн бүхэн цөмөөрөө
Үүрэх сайхан заяатай !
Гэр бүлийн гишүүд нь
Энэ заяандаа бахархаж
Гэгээн тунгалаг нарны доор
Бие хайргүй хөдөлмөрлөж
Ариун цагаан хөдөлмөрөөр
Өөдөлж яваа энэ айлын
Ам бүлийнх нь дансанд
Би өөрөө бүртгэлтэй.
Зулай кимгэн байхад минь
Гэр бүлээрээ бөөцийлж
Зулзаган залуу явахад минь
Эрдэм соёлоор гэгээрүүлж
Өнөр өтгөн бүлийнхээ
Нэгэн гишүүнд эр[illegible] [illegible]илсөн
Өлзий буянтай энэ айлын

Хүн бүхэнд би эртэй.
Тэнгийн ачаа даахаар
Эр бие минь өсөхийн үед
Тэнгэрийн өөхий атгуулан
Гар дээрээ өргөж
Элгэн хамт олноороо
Надад оноосон ачааг
Энэ биеэрээ би
Нартад үүрэх учиртай !

Хүн бүхэн өөрийнхөө
Ачааг даах явбал
Хүйлэн хөх тэнгэрийн доор
Манайх хэзээ ч алзахгүй
Хүнд дараа болохгүй
Ачаагаа даах явбал
Халуун ам бүлийнхээ дунд
Би өөрөө алзахгүй.
Учрыг ингэж бодохлоор
Хэрсүү ухаанаар сэтгэж
Ургах сартай шөнөөр

Нойргүй хоноолгүй болохгүй.
Унаж босож явахад минь
Зөөлөн гараар дэмнэсэн
Ухаан тэгс олныхоо
Ачийг хариулалгүй болохгүй.
Эцэг өвгөдийн заншлыг
Алга тосон уламжилж
Энэ яваа насандаа
Биеэ чимэлгүй болохгүй.
Ахмад үеийнхээ жишээг
Өөрийн биеэр үзүүлж
Алдрай жаахан ач нартаа
Өвлөж өгөлгүй болохгүй.

Сүх жанжны өргөсөн
Улаан тугийн дэрвээн доор
Сүр хүчээ нэгтгэн
Ууган түрлэг өргөж
Эрх чөлөөний нарыг
Тоонон дээр минь мандуулсан
Эрэлхэг олон хувьсгалчдынхаа



此为试读,需要完整PDF请访问: www.ertongbook.com

Дайчин сайхан уламжлалыг
Өөрсдөөс нь шууд хүлээн авч
Өөрийн биеийг хүмүүжүүлээд
Хойч үедээ уламжлах
Хувь заяандаа баярлаж байна.
Ази тивийн элгэн дээр
Айл гэрийг минь шинэчилж
Ам бүлийн минь заяаг
Алтан нар шиг гийгүүлж
Олон түмний минь нэгдлийн
Оройн сүлд болсон
Ардын хувьсгалт намынхаа
Агуу эгнээнд багтаж
Энгүй сайхан нутагтаа
Эзэн хүн шиг алхах
Эрх жаргал хайрласан,
Эх орондоо баярлаж байна.
Талын морьтны удам
Манай ам бүлийг
Тэнгэр цэнхэр бөмбөрцөг дээр

Өдий зэрэгтэй өөдлөхөд
Үнэнч андын гараараа
Үйлс заланд минь тусалсан
Өнөр Зөвлөлтийн хүмүүстэй
Үүрд биднийг нөхөрлүүлсэн
Манлай холоодогч намдаа
Магнай хагартал баярлаж байна.
Нэг нь нийтийнхээ төлөө
Амь амьдралаа зориулж
Нийт нь нэгийнхээ төлөө
Аль байдгаа зориулж
Улс гэрийнхээ ачааг
Нуруун дээрээ үүрч
Уудам сайхан орныхоо
Нарлаг ирээдүйг ойртуулж
Ариун цагаан хөдөлмөрийг
Амиа болгож шүтсэн
Ажилчин малчин сэхээтний
Ам бүлдээ баярлаж байна.
"Монгол гэдэг нэгэн нэр
Ертөнцийн чихнээ дуурсаж"

Манайх гэдэг нэгэн айл
Ерөөлийн сайхнаар цэцэглэж
Өвгөд хөгшид маань хүртэл
Өтөл өдөр суухаа больж
Үр хүүхэд, ач гуч маань
Үзэсгэлэн гоо төрдөг болж
Ургах улаан нар шиг
Урдах зам минь гэрэлтэй
Унтаад босгох маргаашийн
Угтах заяа тодорхой.
Айл гэрийн минь хийморь
Аранзал туг шиг гэрэлтэж
Ард олны минь зүтгэл
Рашаан булаг шиг оргилж
Юм бүхэн маань цаанаа л нэг
Өөдрөг сайхан болохлоор
Ерөөлтэй сайхан нутаг минь
Өнгөжин цэцэглээд ирэхлээр
Уудам сайхан хорвоод
Урт удаан насалж
Ураг элгэн түмэндээ

Улам ихийг бүтээж
Алтан шаргал нарны доор
Амьд явах хүсэл
Аавын хүүгийн цээжинд
Аяндаа багтаж ядах юм.
Ээлтэй сайхан орон минь
Эгнэгт дандаа цэцэглэг гэж
Эвийн сайхан ам бүл минь
Энх амгалан амьдраг гэж
Санаа нэгтэй ах дүүс нь
Сар нар шиг мандаг гэж
Садан төрлийн сүлбээ нь
Салаа зандан шиг дэлгэрэг гэж
Хүн төрөлхтөн хоорондоо
Эв найртай байг гэж
Хүж дэлхий даяараа
Энх амгалан оршиг гэж
Амьд явах насны
Андгай болгон ерөөж
Алтан нартай хорвоог
Алаг зүрхнээс хайрлах юм !

Хүннүгийн үеэс идээшсэн
Хөдөө талаараа тархаж
Хүн бүхэн биенээсээ
Хөндий тасархай амьдарч
Гон биеийн жаргалыг хөөж
Гозон толгой амиа бодож
Бурангуй хуучин ёсонд
Бүлт олноороо хүлэгдэж
Бурхны хоосон шашинд
Буян заяагаа даатгаж
Алдаж онож явсан
Өвөг дээдсийн минь түүх
Айл хөршөөсөө хоцорсон
Өвгөд эмгэдийн минь намтар
Өнөөдөр бидэнд ойлгомжтой
Өр зүрхэнд сургамжтай.
Халуун ам бүлээрээ
Нэгэн гэр бүлд нэгдэж
Хамт олон цөмөөрөө
Нэгэн санаа өвөрлөх

Айл хөршөө гүйцэж
Арчаагүй хоцрогдлыг арилгаж
Эв хамтын ёс
Эх орондоо минь мандах
Энэ сайхан үед
Ирээдүй хэтийн замд
Халуун ам бүлийнхээ
Ямар ч хүнд ачааг
Хамгийн түрүүнд үүрэх
Тэнхээ зориг нэмэх юм.
Алдар нэр нь Монгол гэдэг
Ам бүл нь Манайх гэдэг
Энэ сайхан айлынхаа
Ирээдүй жаргалын төлөө
Хүн бүхэн өөрийнхөө
Ачааг даах явбал
Хүйлэн хөх тэнгэрийн доор
Манайх хэзээ ч алзахгүй
Хүнд дараа бололгүй
Ачаагаа даах явбал



此为试读,需要完整PDF请访问: www.ertongbook.com